



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

№ 03.25 / 720


Танай _____ -ны № _____ -т

「НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА Ж.АЛДАРЖАВХЛАН ТАНАА」

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж
байна.

Хавсралт... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
М.ЭРДЭНЭЖАРГАЛ



002033537



АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/04/НА-СА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр

Утас: 11327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: С.Гантөгс

Утас: 11315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Баттогоо

Утас: 11325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn

Аудитор: Ж.Мөнхтуяа, Б.Одончимэг

Цахим хаяг: munkhtuyaja@audit.gov.mn

Цахим хаяг: odonchimigb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3.Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.4.2 Авлага	13
3.4.3 Урьдчилгаа	13
3.4.4 Бараа материал.....	13
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	14
3.4.6 Үндсэн хөрөнгө.....	14
3.4.7 Өр төлбөр.....	16
3.4.8 Засгийн газрын хувь оролцоо	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.5.1 Завсрын аудитын талаар	24
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	35

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ НҮА	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар Нийтлэг үйлчилгээний алба
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03.25 № 721

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
Ж.АЛДАРЖАВХЛАН ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хан-Уул дүүрэг нь 2023 онд төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулан дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр байгуулагдсан хороод болон өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор байр, 15 дугаар хороонд 250 ор бүхий цэцэрлэгийн барилгын ажлыг барьж ашиглалтад оруулсан байна.

Эко-Эрүүл дүүрэг үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 260,361 ширхэг мод, бут, сөөг тарьж, шороон хөрс бүхий 46,361.2 м² талбайг зүлэгжүүлж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 15 байршилд нийт 267,519 ширхэг цэцгээр цэцгийн мандал хийсэн бөгөөд дүүргийн 14 дүгээр хорооны Айдсын аманд 100 га газарт ойн зурвас байгуулах ажлын 1 дүгээр ээлжид 10 га газрыг ойжуулан, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан байна.

Тус дүүрэг нь “Хоггүй-Хан-Уул” аяныг тогтмол хэрэгжүүлэн, нийтийн эзэмшлийн зам, талбайн ашиглалт, арчилгааг сайжруулах хүрээнд замын цэвэрлэгээ, усалгааны автомашин, хог тээврийн зориулалтын 8 автомашинуудыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авч, хог тээврийн үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн өмчит газруудад автомашины парк шинэчлэлт хийсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63,047,547.8	115,279,426.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,832,394.0	87,224,908.4
33	АВЛАГА	191,270.9	165,709.0
34	УРЬДЧИЛГАА	4,428,751.3	3,368,823.8
35	БАРАА МАТЕРИАЛ	1,252,979.1	2,150,300.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	16,342,152.6	22,369,684.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	139,961,452.4	148,744,920.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	139,961,452.4	148,744,920.6
39200	Биет хөрөнгө	137,093,503.5	145,774,533.0
39300	Биет бус хөрөнгө	2,858,253.8	2,970,387.5
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	9,695.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>203,009,000.2</u>	<u>264,024,346.9</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,157,410.5	4,065,367.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,157,410.5	4,065,367.8
41300	Өглөг	8,104,813.6	1,604,820.2
41400	Урьдчилж орсон орлого	52,596.9	2,460,547.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	194,851,589.7	259,958,979.1
51	Засгийн газрын хувь оролцоо	194,851,589.7	259,958,979.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	20,087,911.5	21,805,055.7
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	566,955.0	739,735.0
51200	Хуримтлагдсан үр дүн	143,211,475.7	206,458,340.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,985,247.5	30,955,848.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>203,009,000.2</u>	<u>264,024,346.9</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	270,052,366.8	377,650,281.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	228,036,396.7	347,752,591.5
110	Орлогын албан татвар	175,761,257.7	272,191,348.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	175,761,257.7	272,191,348.9
113	Хөрөнгийн албан татвар	16,085,101.4	19,615,441.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,190,037.7	55,945,800.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,010,086.6	27,844,141.3
120	Нийтлэг татварын бус орлого	38,857,302.1	25,999,117.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,152,784.5	1,845,023.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,005,883.4	2,053,549.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	211,204,753.9	294,454,096.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	211,204,753.9	294,454,096.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,940,809.7	68,444,796.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,181,027.3	12,274,152.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,220,124.3	1,573,814.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,549,653.0	6,015,973.6

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	1,746,248.6	1,872,358.5
2105	Нормативд зардал	14,712.0	6,970.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,785,822.4	3,038,099.6
2107	Томилолт, зочны зардал	121,743.3	673,885.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,123,123.6	20,313,872.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,198,355.1	22,675,669.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,263,994.3	226,009,300.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	58,847,612.8	83,196,185.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	93,138,753.3	19,293,042.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(34,291,140.5)	63,903,143.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	20,654,866.5	30,985,247.5	143,211,475.7	194,851,589.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,654,866.5	30,553,924.0	177,502,616.2	228,711,406.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(30,411,625.1)	(17,798,720.0)	47,822,040.5	(388,304.5)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	431,323.5	-	431,323.5
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(34,291,140.5)	(34,291,140.5)
11	2023 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл	20,654,866.5	30,985,247.5	143,211,475.7	194,851,589.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,654,866.5	30,985,247.5	143,224,187.3	194,864,301.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	656,278.6	656,278.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	(29,399.5)	-	(29,399.5)
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,889,924.2	-	-	1,889,924.2
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	63,903,143.4	63,903,143.4
20	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	22,544,790.7	30,955,848.0	206,458,340.4	259,958,979.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	239,388,957.4	357,215,606.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	228,036,396.7	347,752,591.5
110	Орлогын албан татвар	175,761,257.7	272,191,348.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	175,761,257.7	272,191,348.9
113	Хөрөнгийн албан татвар	16,085,101.4	19,615,441.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,190,037.7	55,945,800.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,766,368.0	24,590,266.4
1181	Газрын төлбөр	28,406,469.8	31,333,813.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	17,200.0	21,720.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,287,572.5	7,409,465.3
120	Нийтлэг татварын бус орлого	8,134,788.2	5,564,442.0

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,152,784.5	1,845,023.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,064,988.1	2,053,549.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,643,159.0	285,512,462.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,643,159.0	285,512,462.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,478,660.9	52,385,813.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,948,971.7	17,501,228.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,354,021.8	2,846,091.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,961,796.4	6,585,272.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,421,133.3	3,349,438.2
2105	Нормативд зардал	15,713.9	24,252.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,890,001.4	3,752,431.6
2107	Томилолт, зочны зардал	121,743.3	702,681.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,340,450.2	12,542,959.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,424,828.9	5,081,458.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,164,498.1	233,126,648.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	49,745,798.4	71,703,144.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	28,060,114.7	25,310,629.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,060,114.7	25,310,629.6
2200	Дотоод эх үүсвэрээр	28,060,114.7	25,310,629.6
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(28,060,114.7)	(25,310,629.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	21,685,683.8	46,392,514.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,146,710.2	40,832,394.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,832,394.0	87,224,908.4

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	354,276,226,400.0	306,268,126,469.9	48,008,099,930.1	86.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,748,323,100.0	283,181,670,185.9	21,566,652,914.1	92.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,708,180,100.0	51,007,507,044.9	18,700,673,055.1	73.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,788,646,900.0	9,881,744,139.7	1,906,902,760.3	83.8
210101	Үндсэн цалин	3,938,706,600.0	3,691,840,810.6	246,865,789.4	93.7
210102	Нэмэгдэл	1,970,650,900.0	1,065,785,096.4	904,865,803.6	54.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,214,786,000.0	954,904,535.0	259,881,465.0	78.6
210104	Урамшуулал	1,739,704,800.0	1,746,689,317.8	(6,984,517.8)	100.4
210105	Гэрээт ажлын хөлс	2,924,798,600.0	2,422,524,379.9	502,274,220.1	82.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,619,267,300.0	1,203,970,819.9	415,296,480.1	74.4
210201	Тэтгэврийн даатгал	1,138,710,200.0	833,369,215.8	305,340,984.2	73.2
210202	Тэтгэмжийн даатгал	119,206,300.0	98,919,592.5	20,286,707.5	83.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	96,111,300.0	78,481,947.8	17,629,352.2	81.7
210204	Ажилгүйдлийн даатгал	23,094,700.0	16,319,108.2	6,775,591.8	70.7
210205	Эрүүл мэндийн даатгал	242,144,800.0	176,880,955.6	65,263,844.4	73.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,186,470,600.0	5,747,005,987.1	4,439,464,612.9	56.4
210301	Гэрэл, цахилгаан	2,981,344,000.0	1,672,771,544.1	1,308,572,455.9	56.1
210302	Түлш, халаалт	4,022,404,400.0	2,184,109,652.4	1,838,294,747.6	54.3
210303	Цэвэр, бохир ус	2,598,251,700.0	1,359,942,418.0	1,238,309,282.0	52.3
210304	Байрны түрээс	584,470,500.0	530,182,372.6	54,288,127.5	90.7
2104	Хангамж, бараа материалын зардал	9,190,352,400.0	8,997,916,782.1	192,435,617.9	97.9
210401	Бичиг хэрэг	236,099,200.0	194,887,045.0	41,212,155.0	82.5

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	131,200,000.0	124,400,000.0	6,800,000.0	94.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	223,000,000.0	158,289,307.1	64,710,692.9	71.0
210404	Ном, хэвлэл	94,900,000.0	59,317,860.0	35,582,140.0	62.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,171,934,400.0	8,130,391,075.0	41,543,325.0	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	333,218,800.0	330,631,495.0	2,587,305.0	99.2
2105	Нормативд зардал	13,600,000.0	11,174,000.0	2,426,000.0	82.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,200,000.0	1,200,000.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,400,000.0	9,974,000.0	2,426,000.0	80.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,298,013,200.0	2,141,481,265.0	156,531,935.0	93.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	271,520,500.0	207,750,110.0	63,770,390.0	76.5
210602	Тавилга	277,038,000.0	219,428,560.0	57,609,440.0	79.2
210604	Урсгал засвар	1,749,454,700.0	1,714,302,595.0	35,152,105.0	98.0
2107	Томилолт, зочны зардал	832,978,000.0	678,962,704.9	154,015,295.1	81.5
210701	Гадаад албан томилолт	535,900,000.0	459,832,569.8	76,067,430.2	85.8
210702	Дотоод албан томилолт	40,878,000.0	4,395,810.0	36,482,190.0	10.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	256,200,000.0	214,734,325.1	41,465,674.9	83.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,074,078,400.0	18,001,220,783.3	11,072,857,616.7	61.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,773,944,200.0	17,814,145,646.0	10,959,798,554.0	61.9
210803	Даатгалын үйлчилгээ	11,635,000.0	9,868,809.3	1,766,190.7	84.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,369,700.0	4,644,199.0	725,501.0	86.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	600,000.0	132,000.0	468,000.0	22.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	211,300,000.0	113,706,808.0	97,593,192.0	53.8
210807	Газрын төлбөр	71,229,500.0	58,723,321.0	12,506,179.0	82.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,704,773,300.0	4,344,030,563.0	360,742,737.0	92.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,693,273,300.0	4,333,610,563.0	359,662,737.0	92.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,500,000.0	10,420,000.0	1,080,000.0	90.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	235,040,143,000.0	232,174,163,141.0	2,865,979,859.0	98.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	233,638,007,100.0	230,815,575,535.0	2,822,431,565.0	98.8
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	233,638,007,100.0	230,815,575,535.0	2,822,431,565.0	98.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,402,135,900.0	1,358,587,606.0	43,548,294.0	96.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,029,500.0	14,234,492.0	1,795,008.0	88.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,823,800.0	59,384,737.0	2,439,063.0	96.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,324,282,600.0	1,284,968,377.0	39,314,223.0	97.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,527,903,300.0	23,086,456,284.0	26,441,447,016.0	46.6
220001	Барилга байгууламж	26,482,578,600.0	22,497,182,924.0	3,985,395,676.0	85.0
222001	Тоног төхөөрөмж	4,818,065,600.0	430,563,111.0	4,387,502,489.0	8.9
223001	Бусад хөрөнгө	18,227,259,100.0	158,710,249.0	18,068,548,851.0	0.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	354,276,226,400.0	307,221,517,709.9	47,054,708,690.1	86.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,873,430,200.0	1,845,023,375.0	28,406,825.0	98.5
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас	1,873,430,200.0	1,845,023,375.0	28,406,825.0	98.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	323,734,682,300.0	304,968,364,147.9	18,766,318,152.1	94.2
320001	Орон нутгийн төсвөөс	323,734,682,300.0	304,968,364,147.9	18,766,318,152.1	94.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,668,113,900.0	408,130,187.0	28,259,983,713.0	1.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	607,040,600.0	408,130,187.0	198,910,413.0	67.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	28,061,073,300.0	-	28,061,073,300.0	0.0
4	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,799,633,535.0	(1,799,633,535.0)	0.0
5	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,753,024,775.0	(2,753,024,775.0)	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,140.0	1,128.0	12.0	98.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8.0	8.0	-	100.0

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

610001	Төсвийн байгууллага	8.0	8.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	566.0	560.0	6.0	98.9
620001	Удирдах ажилтан	51.0	51.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	214.0	208.0	6.0	97.2
620003	Үйлчлэх ажилтан	296.0	296.0	-	100.0
620004	Гэрээт ажилтан	5.0	5.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	566.0	560.0	6.0	98.9
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	168.0	161.0	7.0	95.8
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6.0	6.0	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	13.0	13.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	343.0	343.0	-	100.0
650010	Гэрээт ажилтан	5.0	5.0	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	32.0	32.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,111,868,177.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,111,868,177.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,148,480,386.00
2104	Хангамж, бараа материалын зардал	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	540,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,690,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,950,000.00
210602	Тавилга	12,600,000.00
210604	Урсгал засвар	4,140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	322,059,571.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	322,059,571.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	801,190,815.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	801,190,815.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	963,387,791.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,820,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	881,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,820,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,567,791.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	62,567,791.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,111,868,177.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,111,868,177.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,499,476,125.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	612,392,052.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Хан-Уул дүүргийн алсын харааг “Хүнээ эрхэмлэн дээдэлсэн, хүн амын хэрэгцээ шаардлага, дүүргийн онцлогт зохицсон дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх замаар эрүүл аюулгүй орчинтой тэргүүлэгч дүүрэг болно.” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгоо “Төр, иргэн, хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, бүтээлч оролцоонд тулгуурлан төрийн албан хаагчдыг чадварлаг тогтвортой, хариуцлагатай баг бүхий төрийн үйлчилгээний загвар болоход оршино.” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг нээлттэй, хөнгөн шуурхай, ил тод болгох замаар төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх.
- Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг мэргэшүүлэх, урамшуулах, ахиулах зарчмыг баримтлан мэргэшсэн, чадварлаг, туршлагатай хүний нөөцийн баг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангуулах.
- Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлж, мэдээллийн технологиор тэргүүлэх дүүрэг болох.
- Гадаад орны ижил төрлийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагааг дүүргийн дахин төлөвлөлт, байгаль орчин, хөдөө аж ахуй, боловсролын хөгжил рүү чиглүүлэх.
- Төрийн захиргааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, дүүрэг эдийн засгийн хувьд бие дааж хөгжих.
- Дүүргийн хөгжлийг тодорхойлохуйц тохижилт, бүтээн байгуулалт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулж, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Байгаль орчинд ээлтэй “ЭКО – ДҮҮРЭГ” болох
- Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний салбарт бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагуудыг хууль, тогтоомжийн хүрээнд дэмжиж, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, дүүргийн эдийн засгийн бааз суурийг бэхжүүлэхэд чиглүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа салбарын дараах хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Татварын багц хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 тогтоолоор төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталж хэрэгжсэн.
- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ шинэчлэн баталсан.
- ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам" баталж 9 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.
- ЗГ-ын 442 дугаар тогтоолоор "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын тав дугаар бүлэгт өөрчлөлт орж 12 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн байна.
- ЗГ-ын 203 дугаар тогтоолоор "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай журам" тогтоолууд шинэчлэн батлагдсан байна.
- ЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолоор баталсан журамд өөрчлөлт оруулах журмын 5 дах заалтад ЗГ-ын 2022 оны 489 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орж 2023 оны 1 дүгээр сарын 2-оос хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба нь дүүргийн Засаг даргын баталсан 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу 33 байгууллагад төлөвлөгөөт аудит хийж, биелэлтийг бүрэн хангаж ажилласан. Мөн дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 4 байгууллагын цалин хөлс олголт, ТУЗ-ийн шийдвэр, бүтэц орон тоонд хяналт шалгалт хийж Засаг даргад хүргүүлэн, Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу 2 удаа аудит хийж тайлан, мэдээ судалгааг гарган төлөвлөгөөний биелэлтийг 100% хангаж ажиллажээ.

Аудитаар нийт 1,182,938.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 13,381.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 449,734.9 мянган төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлж, 719,821.7 мянган төгрөгийн 93 зөвлөмж өгсөн байна. Актын биелэлт 13,381.4 мянган төгрөг буюу 100 хувь, 427,248.1 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлт 95 хувь, 698,227.0 мянган төгрөгийн зөвлөмжийн биелэлт 97 хувь хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Хан-Уул дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилго нь дүүргийн төсөвт байгууллагын хяналтад байгаа бүх хөрөнгө, эх үүсвэр, өр төлбөрийг багтаасан санхүүгийн нэгдсэн дүн, Засгийн газрын хүлээсэн үүрэг, хариуцлагын биелэлтийн талаарх үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэх явдал юм.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцэж*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,015,346.7 мянган төгрөгөөр буюу 30.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	40,832,393.9	87,224,908.4	46,392,514.5
Авлага	191,270.8	165,709.0	(25,561.8)
Урьдчилгаа	4,428,751.3	3,368,823.8	(1,059,927.5)
Бараа материал	1,252,979.1	2,150,300.3	897,321.2
Бусад эргэлтийн хөрөнгө	16,342,152.6	22,369,684.8	6,027,532.2
Үндсэн хөрөнгө	139,961,452.4	148,744,920.6	8,783,468.2
Нийт хөрөнгө	203,009,000.2	264,024,346.9	61,015,346.7
Өр төлбөр	8,157,410.5	4,065,367.8	(4,092,042.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	194,851,589.7	259,958,979.1	65,139,546.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	203,009,000.2	264,024,346.9	61,015,346.7

Эх сурвалж: “Хан-уул дүүргийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Дээрх хүснэгтээс харахад 61,015,346.7 мянган төгрөгөөр өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данстууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 87,224,908.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 46,392,514.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Кассад байгаа бэлэн мөнгө	98,748.9	2,358.3	(96,390.6)
Банканд байгаа бэлэн мөнгө	3,401,666.5	77,718,927.8	44,317,261.3
Үүнээс: Төрийн сангийн харилцах	32,101,385.4	76,743,070.1	44,641,684.7
Арилжааны банк дахь харилцах	1,300,281.1	975,857.7	(324,423.4)
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	7,331,978.6	9,503,622.3	2,171,643.7
Дүн	40,832,394.0	87,224,908.4	46,392,514.4

Эх сурвалж: “Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 44,641,684.7 мянга, замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,171,643.7 мянган төгрөгөөр өссөн нь 2023 оны төсвийн орлого давж биелснээс шалтгаалжээ. Арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл 324,423.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг тайлант хугацаанд зарцуулснаас шалтгаалсан байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 165,709.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,561.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Ажиллагсадтай холбоотой авлага		5,950.0	5,950.0
Дансны авлага /ТӨҮГ/	61,907.9	46,134.0	(15,773.9)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	129,230.9	76,233.6	(52,997.3)
Байгууллагаас авах авлага	132.0	3,332.0	3,200.0
Хувь хүмүүсээс авах авлага		34,059.4	34,059.4
Дүн	191,270.8	165,709.0	(25,561.8)

Эх сурвалж: "Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь татвар, НДШ-ийн авлага, байгууллагаас авах дансны авлагууд барагдсан, хувь хүмүүс, ажиллагсадтай холбоотой авлага нэмэгдсэн нь түрээсийн орлого 18,026.3 мянган төгрөгөөр дутуу орж ирсэн, жолооч нар зам тээврийн осол гаргаж иргэдэд учруулсан хохирлын 19,233.1 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрээр байгууллагаас төлж авлага үүсгэсэн, ажилчдад илүү олгосон 5,950.0 мянган төгрөгийн урамшууллыг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 3,368,823.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,059,927.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Урьдчилгаа тооцоо	4,428,751.3	3,368,823.8	1,059,927.5
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			-
Дүн	4,428,751.3	3,368,823.8	1,059,927.5

Эх сурвалж: "Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,059,927.5 мянган төгрөг болж буурсан нь 16 дугаар хороонд 200 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч Гранд марз групп ХХК-д 2,489,030.2 мянга, Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгч Рокранд ХХК-д 624,449.6 мянга, 19, 20,11 хороодод явган хүний зам хийх тохижилтын ажлын гүйцэтгэгч Эко эвсэг зам ХХК-д 255,344.0 мянга, нийт 3,368,823,8 мянган төгрөгийг гэрээний дагуу арилжааны банкны ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг олгосон нь тайлант хугацааны урьдчилж гарсан зардалд тайлагнасанатай холбоотой байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,150,300.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 897,321.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Түүхий эд материал	80,605.2	262,247.1	181,641.9
Тусгай зориулалттай материал	80,562.2	262,214.6	181,652.4
Эм боох материал	43.0	32.5	(10.5)
Хангамжийн материал	1,172,373.8	1,888,053.2	715,679.4
Бичиг хэргийн материал	59,533.2	63,678.0	4,144.8
Аж ахуйн материал	167,695.5	192,486.2	24,790.7
Сэлбэг хэрэгсэл	20,925.4	187,049.0	166,123.6
Түлш, шатах тослох материал	46,353.7	46,755.7	(402.0)
Барилгын засварын материал	57,078.9	378,242.3	321,163.4
Бусад хангамжийн материал	820,787.1	1,019,842.1	199,055.0
Дүн	1,252,979.0	2,150,300.3	897,321.3

Эх сурвалж: "Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Бараа материал дансны үлдэгдэл 897,321.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Тусгай зориулалттай материал дансны үлдэгдэл 181,652.4 мянган төгрөгөөр өссөн нь Тохижилт үйлчилгээний төв 162,434.6 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, Соёлын ордон 19,207.3 мянган төгрөгийн хөгжимчдийн урлагийн дээл хувцас зэргийг авч бэлтгэсэнтэй холбоотой.
- Сэлбэг хэрэгслийн материал дансны үлдэгдэл 166,123.6 мянган төгрөгөөр өссөн нь Нийтлэг үйлчилгээний алба нь камерын засвар үйлчилгээнд зориулан 157,897.2 мянган төгрөгийн камерын сэлбэг хэрэгсэл, Хан эко тээвэр, Зам, засвар арчлалт зэрэг ОНӨААТҮГ-уудын сэлбэг хэрэгсэлд 8,226.4 мянган төгрөгөөр худалдан авсантай холбоотой.
- Барилгын засварын материалын үлдэгдэл 321,163.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн байгууллагуудын засварын ажлаас үлдсэн барилгын материалын үлдэгдэл, гагнуурын аппарат, халаагуур, цохилтот өрөм гэх мэт багажуудыг үлдэгдлээр нь тайлагнасан зэргээс шалтгаалсан байна.
- Бусад хангамжийн материалын үлдэгдэл 199,055.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлын бут сөөх, хайлс, шар хуайс зэрэг моднууд 85,003.1 мянган төгрөг, зураг төсөв 114,051.9 мянган төгрөгөөр ЗДТГ-ын дансанд бүртгэж, үлдэгдлээр нь тайлагнасан зэргээс нөлөөлсөн байна.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 22,369,684.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,027,532.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	16,342,152.6	22,369,684.8	6,027,532.2
Дүн	16,342,152.6	22,369,684.8	6,027,532.2

Эх сурвалж: "Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Бусад эргэлтийн хөрөнгө 6,027,532.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2023 онд хийгдэж дууссан 23 ажлын санхүүжилтийг олгосон боловч, хөрөнгийг бүртгэж авах шийдвэр гараагүй учир тус дансанд бүртгэсэн байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 148,744,920.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,783,468.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Биет хөрөнгө	137,093,503.5	145,774,532.9	8,681,029.4
Барилга, байгууламж, орон сууц	24,114,193.5	32,391,954.9	8,277,761.4
Авто-тээврийн хэрэгсэл	4,031,876.1	10,671,038.6	6,639,162.5
Машин тоног төхөөрөмж	1,909,508.8	2,753,730.1	844,221.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	756,171.6	847,083.4	90,911.8
Бусад үндсэн хөрөнгө	14,734,908.3	13,736,594.2	(998,314.1)
Зам гүүрний байгууламж	91,523,436.1	85,315,738.9	(6,207,697.2)
Ном	23,409.1	58,392.8	34,983.7
Биет бус хөрөнгө	2,858,253.8	2,970,387.6	112,133.8
Программ хангамж	34,949.7	90,043.5	55,093.8
Бусад биет бус хөрөнгө	2,823,304.1	2,880,344.1	57,040.0
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	9,695.0	-	(9,695.0)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	9,695.0	-	(9,695.0)
Дүн	139,961,452.3	148,744,920.6	8,783,468.3

Эх сурвалж: “Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Тайлант онд үндсэн хөрөнгө 26,066,440.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 961,982.6 мянган төгрөгөөр хорогдож, жилийн эцсийн үлдэгдэл 251,193,863.0 мянган төгрөг байгаа бөгөөд тайлант хугацаанд 16,659,512.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцогдож, 247,787.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан /холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрлийн дагуу 6 байгууллага – ИТХ, ЗДТГ, УССТ, ОНӨААТҮГ-3/, 714,195.3 мянган төгрөгийн хөрөнгийг ИТХ, ЗДТГ, Соёлын ордон, Усан спорт сургалтын төв, Хан-уул агро, ТҮТ, НҮАлба, Хан-Эко тээвэр, зэрэг байгууллагууд үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн/ 338,523.1 мянган төгрөгийн хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлээр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд 26,066,440.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэний 1,820,767.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 21,441,713.5 мянган төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалт, хандив тусламжаар бэлтгэсэн, 2,392,580.8 мянган төгрөгийн хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлээр нэмэгдсэн байна.

Төсвийн хөрөнгөөр :

- ЗДТГ - 431,376.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
- ИТХ – 13,731.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
- ХААА- 4,865.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж
- ДАА – 10,348.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
- Усан спорт сургалтын төв-18,000.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж
- Туул тосгоны ажлын алба 13,444.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
- Соёлын ордон 28,741.4 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном
- Хан эко тээвэр ОНӨААТҮГ-93,965.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
- Эко хотын тээвэр ОНӨААТҮГ- 68,748.6 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж
- Нийтлэг үйлчилгээний алба-13,806.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил
- Хан-Уул Агро ОНӨААТҮГ- 59,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж
- Эко ахмадын сувилал 96,501.2 мянган төгрөгийн байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 88,291.2 мянган төгрөгийн газар
- ЖДҮДТ – 42,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө тус тус худалдан авсан байна.

Хандив тусламж, хөрөнгө оруулалтаар :

- ЗДТГ- 85,642.9 мянган төгрөг /улсын төсвөөр барилга болон барилгын сайжруулалт/

- ЗДТГ - 17,692,939.2 мянган төгрөг /нийслэл болон дүүргийн хөрөнгө оруулалтаар зам гүүрний ажил /
- Усан спорт сургалтын төв 639,805.0 өргөтгөлийн барилга /дүүргийн хөрөнгө оруулалт/.
- Хан-Уул Агро ОНӨААТҮГ -955,400.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл улсын болон дүүргийн хөрөнгө оруулалт
- Эко хотын тээвэр ОНӨААТҮГ -955,400.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл дүүргийн хөрөнгө оруулалт
- Хан-Эко тээвэр ОНӨААТҮГ-1,103,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл дүүргийн хөрөнгө оруулалт
- Соёлын ордон 323,086.9 мянган төгрөгийн ном, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг төсвийн хөрөнгө оруулалтаар тус тус үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,604,820.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,499,993.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Ажилчидтай холбоотой өглөг	12,315.1	11,657.6	(657.5)
Хувь хүмүүст өгөх өглөг	-	383.5	383.5
Байгууллагад төлөх өглөг	760,628.8	1,298,964.2	538,335.4
Татаас санхүүжилтийн өглөг	7,105,844.5	-	(7,105,844.5)
Татварын өглөг /ТӨҮГ/	157,996.0	240,455.2	82,459.2
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	5,277.3	-	(5,277.3)
Дансны өглөг /ТӨҮГ/	62,751.8	53,359.7	(9,392.1)
Дүн	8,104,813.5	1,604,820.2	(6,499,993.3)

Эх сурвалж: “Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Өглөгийн үлдэгдэл өмнөх оноос буурсан нь нийслэлд төвлөрүүлэх орлогын 7,105,844.5 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн өглөг өгсөн, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын барьцаа чөлөөлөлтийн хугацаа дуусаагүй барьцааны өглөг 538,335.4 мянган төгрөг, 5-н ОНӨААТҮГ-уудын татварын өр 82,459.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 259,958,979.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 65,107,389.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	20,087,911.5	21,805,055.7	1,717,144.2
Эздийн өмчийн бусад хэсэг	566,955.0	739,735.0	172,780.0
Хуримтлагдсан үр дүн	143,211,475.7	206,458,340.4	63,246,864.7
Өмнөх үеийн үр дүн	177,502,616.1	142,546,552.0	(34,956,064.1)
Тайлант үеийн үр дүн	(34,291,140.4)	63,903,143.4	98,194,283.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,985,247.5	30,955,848.0	(29,399.5)
Дүн	194,851,589.7	259,958,979.1	65,107,389.4

Эх сурвалж: “Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Засгийн газрын хувь оролцоо данс 65,107,389.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлаар хөрөнгө нэмэгдэж, тайлан оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хан-Уул дүүргийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 58,257,771.4 мянга, үйл ажиллагааны орлогоос 616,055.3 мянга, нийт суурь зарлагыг 58,873,826.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас суурь зарлагыг 1,562,250.0 мянган төгрөгөөр буруулж, 57,311,579.7 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь ЗГ-ын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох зарим заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим зардлуудыг бууруулж баталснаас шалтгаалжээ.

3.5.2. Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын "Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор анх төсвийн орлогыг нийт 294,674,610.6 мянган төгрөг, өөрийн орлогыг 607,040.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 19,865,736.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг 1,473,571.1 мянган төгрөг, нийт 316,620,959.1 мянган төгрөг, төсвийн зарлагыг 316,620,959.1 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан дүүргийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор төсвийн орлогыг нийт 323,734,682.3 мянган төгрөг, өөрийн орлогыг 607,040.6 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг 1,873,430.2 мянган төгрөг, урьд оны үлдэгдлийг 28,061,073.3 мянган төгрөг, зарлагыг 354,276,226.4 мянган төгрөгөөр тус тус өөрчлөн дахин баталжээ.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

3.5.3.1 Төсвийн орлогын гүйцэтгэл

Тайлант онд 324,341,722.9 мянган төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 350,656,651.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 126,314,928.4 мянган төгрөг буюу 108.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	324,341,722.9	350,656,651.3	26,314,928.4	108.1
11	ТАТВАРЫН ОРЛОГЫН ДҮН	317,693,482.3	347,752,591.5	30,059,109.2	109.5
110	ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ДҮН	208,779,962.3	254,288,112.9	45,508,150.6	121.8
1100	ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР	187,671,698.3	234,672,671.0	47,000,972.8	375.9
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	154,671,698.3	192,997,805.5	38,326,107.2	124.8
110002	Үйл ажиллагааны орлогын албан татвар	18,000,000.0	23,995,910.7	5,995,910.7	133.3
110003	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	15,000,000.0	17,678,954.8	2,678,954.8	117.9
110004	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	20,984,864.0	19,522,937.9	(1,461,926.1)	93.0
110008	Галт зэвсгийн албан татвар	123,400.0	91,966.5	(31,433.5)	74.5
113	Малын албан татвар		537.4	537.4	
113001	БУСАД АЛБАН ТАТВАРЫН ДҮН	108,913,520.0	93,464,478.6	(15,449,041.4)	85.8

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

113002	Улсын тэмдэгтийн хураамж	46,470,000.0	23,011,589.0	(23,458,411.0)	49.5
114	Газрын төлбөр	32,443,520.0	31,333,813.9	(1,109,706.0)	96.6
118	Ус рашааны төлбөр	40,000.0	21,720.3	(18,279.7)	54.3
118001	Хог хаягдлын хураамж	2,300,000.0	1,402,247.7	(897,752.3)	61.0
118006	Түгээмэл Тархацтай АМНАТ	160,000.0	176,429.8	16,429.8	110.3
118009	Үл хөдлөх хөрөнгө, эрх борлуулсны орлого	14,000,000.0	22,889,735.4	8,889,735.4	163.5
1181	Хадгаламжийн хүүгийн орлого	13,500,000.0	14,628,942.5	1,128,942.5	108.4
118101	ТАТВАРЫН БУС ОРЛОГЫН ДҮН	6,041,200.0	2,495,929.6	(3,545,270.3)	41.3
1182	Хүү торгууль, татварын алданги	6,000,000.0	2,265,550.0	(3,734,450.0)	37.8
118203	Ангилалдаагүй бусад орлого	41,200.0	230,379.7	189,179.7	559.2
12	БУСАД ОРЛОГО	607,040.6	408,130.2	(198,910.4)	67.2
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого	607,040.6	408,130.2	(198,910.4)	67.2

Эх сурвалж: "Хан-уул дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Төлөвлөгөө давж буй орлогын төрлүүдийн хувьд:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 38,326,107.2 мянган төгрөг 124.8 хувиар,
- Үйл ажиллагааны орлогын албан татвар 5,995,910.7 мянган төгрөг 133.3 хувиар,
- Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 2,678,954.8 мянган төгрөг 117.9 хувиар,
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 16,429.8 мянган төгрөг 110.3 хувиар,
- Үл хөдлөх хөрөнгө, эрх борлуулсны орлогын албан татвар 8,889,735.4 мянган төгрөг 163.5 хувиар,
- Хадгаламжийн хүүгийн орлого 1,128,942.5 мянган төгрөг 108.36 хувиар тус тус биелсэн байна.

Дээрх орлогууд нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын хувьд аж ахуйн нэгж, байгууллагын дундаж цалин өмнөх оноос 22.4 хувиар нэмэгдсэн, төсөвт байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин өмнөх үеэс 18.3 хувиар нэмэгдсэн нь орлого биелэхэд нөлөөлсөн. Мөн нийгмийн даатгал болон татварын албаны цалингийн сангийн мэдээллийг нэгтгэн уялдуулж, зөрүүг арилгах, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварын ногдуулалт, дутуу төлөлтийг батлагдсан стандартын түвшинд барагдуулж, татвар хураалтыг сайжруулах чиглэлээр ажилласан нь энэ төрлийн орлого нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн байна.

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын хувьд Татварын хуулийн шинэчлэлийн үр дүнд бизнес эрхлэгч иргэдийн хувь хүний орлогын албан татвар тайлагналын хувь өссөнтэй холбоотойгоор 2023 онд хувиараа бизнес эрхлэгчдийн 28 хувь нь татвараа тайлагнадаг болсонтой холбоотой биелсэн.

2023 онд Туул голын сав газрын захиргаанаас ирүүлсэн мэдээ судалгааг үндэслэн, татварын удирдлагын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээдүүдийг нөхөн тайлагнуулж, татварын өрийг барагдуулсан үр дүнд төлөвлөгөө давж биелсэн байна.

Төлөвлөгөө тасарч буй орлогын төрлүүдийн хувьд:

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 8,889,735.4 мянган төгрөгөөр тасарч, 93 хувиар биелэгдсэн нь 2023 оны ногдол үүссэн аж ахуйн нэгжүүд хуулийн хугацаанд төлөлт хийхээр төлөвлөсөн байдаг.
- Газрын төлбөр 1,109,706.0 мянган төгрөгөөр тасарч, 96.6 хувийн биелэлттэй байгаа нь дархан цаазат газарт бүртгэлтэй бөгөөд ногдолтой газруудын газар эзэмших эрхийг сунгах материалаа холбогдох төрийн байгууллагад бүрдүүлж өгсөн ч хугацаа сунгагдахгүй олон жил болж, ногдол нь жил бүр нэмэгдэж, өр өссөн харагддаг тул энэ төрлийн татварын төлөлт тасарсанд нөлөөлсөн, төрөөс газар эзэмших эрхийг цуцалсан шийдвэрийг тухайн татвар

төлөгч зөвшөөрөхгүй шүүхэд хандан шийдвэрлүүлэхээр гомдол гаргадаг бөгөөд шүүхийн шийдвэр гарахгүй олон жил үргэлжилж, газрын төлбөрийн ногдол нь энэ хугацаанд нэмэгдсээр байдаг.

- Улсын тэмдэгтийн хураамж 23,458,411.0 мянган төгрөгөөр тасарч, 49.5 хувийн биелэлттэй байгаа нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс дүүргийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шилжиж ирсэнтэй холбоотойгоор 2023 оны улсын тэмдэгтийн хураамжийн жилийн төлөвлөгөөг нэмж баталсан боловч тухайн онд тус яамны орлого нь төлөвлөснөөс дутуу орж ирсэн, улирлын шинж чанартай олгогддог тусгай зөвшөөрлөөс хамааран улсын тэмдэгтийн хураамжийн орлого тухайн жилд буурсантай холбоотой.
- Галт зэвсгийн албан татвар 31,443.5 мянган төгрөгөөр тасарч, 74.5 хувиар биелэгдсэн нь Цагдаагийн Ерөнхий газар болон Татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэлтэй галт зэвсэг эзэмшигчдийн мэдээлэл зөрүүтэй, хөрөнгийн бүртгэл давхардсанаас үүдэн энэ төрлийн татварын гүйцэтгэл буурахад нөлөөлжээ.
- Төсөвт байгууллагын өөрийн орлогын тухайд Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ, Усан спорт сургалтын төв ОНӨУТҮГ, Эко Ахмадын сувилал зэрэг байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан. Нийтлэг үйлчилгээний албаны хувьд орлогын төлөвлөгөөнд Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн түрээсийн орлого хамаардаг бөгөөд Татварын хэлтэс нь Нийслэлийн өмчийн харилцааны газартай гэрээ байгуулж, Мэргэжлийн хяналтын хэлтэс нь татан буугдсан, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс цаг тухайд төлбөрөө төлөөгүй шалтгаанаар орлогын төлөвлөгөө тасарсан. Усан спорт сургалтын төвд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-с дулааны эрчим хүчээр хангадаг дулааны шугамыг бүрэн солих засварын ажил, агааржуулалтын хоолойг засварлах ажлууд хийж, үйл ажиллагааг түр хугацаанд хааснаас шалтгаалан орлогын төлөвлөгөө тасарсан зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байна.

3.5.3.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 37,655,267.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Энэ нь 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Нийслэлийн ИТХ-ын “ Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 85 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл, хэсгийн ахлагч нарын урамшууллын зардал болон Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүн тус тус нэмэгдсэнтэй холбоотой.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нийгэм эдийн засгийн 5 бүлэг, 108 зорилт бүхий хөтөлбөрийн 151 арга хэмжээг санхүүжүүлэхээр 323,734,682.3 мянган төгрөгийг дүүргийн татварын болон татварын бус орлогоос, 607,040.6 мянган төгрөгийг төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 1,873,430.2 мянган төгрөгийг Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогоос, 28,061,073.3 мянган төгрөгийг дүүргийн төсвийн урьд оны үлдэгдлээс тус тус бүрдүүлэхээр баталсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 306,268,126.5 мянган төгрөг буюу 86.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 48,008,100.0 мянган төгрөг, үүнээс бараа, ажил үйлчилгээний зардал 18,700,673.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2,865,979.9 мянган төгрөг, хөрөнгийн зардал 26,441,447.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70105.Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,499,051.9	3,097,377.7	401,674.2	88.5%
2	70106.Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	254,695,982.0	251,133,412.1	3,562,569.9	98.6%
3	70418.Худалдан авах ажиллагаа	406,692.0	308,093.3	98,598.7	75.7%
4	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	588,554.2	437,120.1	151,434.1	74.3%
5	70501 Орон нутгийн төсөвт олгох шилжүүлэг	3,673,063.7	891,632.1	2,781,431.6	24.3%
6	70503 Орон нутгийн зорилтот ХО-т	49,527,903.3	23,086,456.3	26,441,447.0	46.6%

7	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	497,103.2	487,557.7	9,545.5	98.1%
8	71502 Хот байгуулалт, тохижилт	28,799,187.7	18,541,994.1	10,257,193.6	64.4%
9	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	137,519.2	132,561.4	4,957.8	96.4%
10	71701 Биеийн тамир спорт	893,272.1	700,797.9	192,474.2	78.5%
11	71702 Соёл урлаг	729,045.5	671,521.5	57,524.0	92.1%
12	71801 Сургуулийн өмнөх боловсрол	4,314,886.7	2,548,558.2	1,766,328.5	59.0%
13	71802 Ерөнхий боловсрол	5,661,575.7	3,394,387.9	2,267,187.8	59.9%
14	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	123,360.0	117,196.8	6,163.2	95.0%
15	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	499,524.2	489,954.1	9,570.1	98.1%
16	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	229,505.0	229,505.0	-	100.0%
	Нийт	354,276,226.4	306,268,126.5	48,008,100.2	78.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан орлого 1,499,476.1 мянга, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 612,392.1 мянга, нийт 2,111,868.2 мянган төгрөгийн санхүүжилт оржээ. Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 1,148,480.4 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 881,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зардалд 19,820.0 мянга, нийт 2,049,300.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 62,567.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2023 оны “Хан-Уул дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 25 дугаар тогтоолоор он дамжсан 37 төсөл, арга хэмжээний 15,479,400.0 мянга, 2023 онд хэрэгжих 60 төсөл, арга хэмжээний 34,048,500.0 мянга, нийт 49,572,900.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр баталжээ.

Хөрөнгө оруулалтын 50 төсөл, арга хэмжээнд нийт 23,086,456.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд 21,726,041.6 мянга, техник хяналтын зардалд 186,178.2 мянга, барьцаа дансанд 900,963.0 мянга, зохиогчийн хяналтын зардалд 127,826.0 мянга, зураг төсөвт 76,681.7 мянга, магадалшгүй ажлын зардал 68,765.8 мянган төгрөгийг тус тус олгож, үлдэгдэлгүй тайлагнасан байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалт:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2023 оны “Хан-Уул дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 25 дугаар тогтоолоор он дамжсан 6 арга хэмжээний нийт 1,710,141.5 мянга, 2023 онд хэрэгжих 4 төсөл, арга хэмжээний 1,962,922.2 мянга, нийт 3,673,063.7 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр нийслэлийн ОНХС-ийн эхний үлдэгдэл 1,799,633.5 мянга, тайлант онд 1,845,023.4 мянган төгрөгийн орлого орсноос гүйцэтгэгч байгууллагад 864,968.6 мянга, барьцаа

дансанд 26,663.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 2,753,024.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт барьцаа хөрөнгө:

Дүүргийн барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 760,628.8 мянган төгрөг байснаас 927,626.5 мянган төгрөгийн барьцааг нэмж байршуулж, 30 төсөл, арга хэмжээнд нийт 399,513.7 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж, оны эцэст 60 төсөл, арга хэмжээний 1,288,741.6 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

3.5.6 ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2023 оны “Хан-Уул дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 11 дүгээр тогтоолоор ОНӨААТҮГ-уудын төлөвлөгөөг 22,341,262.8 мянган төгрөгөөр баталжээ.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ОНӨААТҮГ нь 2023 онд нийт 22,341,262.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 17,376,954.4 мянган төгрөгийг зарцуулж, 4,964,308.4 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.

Орлого өмнөх оныхоос 629,894.8 мянган төгрөг, зардал 1,450,123.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Энэ нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гол нөлөө үзүүлсэн байна.

Дүүргийн ЗД-ын баталсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө 22,341,262.8 мянган төгрөг буюу 100.0 хувиар биелүүлсэн, зардал 18,827,077.6 мянган төгрөг буюу 84.3 хувиар дутуу зарцуулжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материал, үндсэн хөрөнгийг үнэн зөв бүртгэж тайлагнах, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, авлага, өглөгийг тухай бүр тооцоо нийлж, актаар баталгаажуулах, төсвийг үр ашигтай зөв удирдаж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, зардлын тооцооллыг үнэн зөв хийх, шилэн данс, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор Н.Баттогоо, аудитор Ж.Мөнхтуяа, Б.Одончимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2024 оны 3 дугаар сарын 4-ны өдрийн 01/367 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 211,204,753.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,168,071.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 2,376,053.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой тус дүүрэг нь 2023 онд төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 354,276,226.4 мянган төгрөг байхаас гүйцэтгэлээр 306,268,126.5 мянган төгрөгийг зарцуулж, 48,008,100.2 мянган төгрөг хэмнэж ажилласан байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 18,700,673.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2,865,979.9 мянган төгрөг, хөрөнгийн зардал 26,441,447. мянган төгрөг хэмнэгдсэн байна .

Цалингийн зардал хэмнэгдсэн нь орон тоо дутуу ажилласан, бүтэц орон тоог өмнөх оноос нэмэгдүүлээгүйгээс шалтгаалжээ.

Байр ашиглалттай холбоотой зардал хэмнэгдсэн нь тайлант онд урсгал засвар болон их засварын ажил хийгдэж дулаан, цахилгаан цэвэр бохир усны зардал багассан нь нөлөөлсөн байна.

Илрүүлэлт:1 Тус газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүд нь бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашиглаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид

бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна. /ЗДТГ, ИТХ, ТҮТ/

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүдийг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар солих зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад өгч ажиллалаа.

Илрүүлэлт:2 Тус байгууллагуудын нь тайлант онд албан хэрэгцээнд 63,894.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, нэр бүхий аж ахуйн нэгжүүдээс шууд худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "*Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно*", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-д "*ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно*" гэж заасантай тус тус нийцээгүй байна. /Дотоод аудит-10.348.6 мянга, ЖДҮДТ-15.800 мянга, Туул тосгоны ажлын алба-13,444.0 мянга, Усан спорт сургалтын төв, Хан-эко тээвэр-7,110.0 мянга, Эко ахмадын сувилал-17,192.1 мянга/

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад өгч ажиллалаа.

Илрүүлэлт:3 Тус газрын үндсэн хөрөнгөд 37 барилга бүртгэлтэй байна. Үүнээс нэгдсэн халаалтын системд холбогдсон 25 барилгуудад барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах тоолуур байхгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 "*нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах*; заалтыг хэрэгжүүлээгүй байна. /ЗДТГ/

Шийдвэрлэсэн нь: Барилга байгууламжуудыг хэмнэлтийн горимд тохируулж, дулааны тоолуур ашиглаж, төсвийн зардлыг хэмнэлттэй зарцуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг шалгагдагч байгууллагад өгч ажиллалаа.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар Нийслэлийн Хан-Уул дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 18 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

1. Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө захиран зарцуулсан шийдвэрийн 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, таван сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 40,786.9 мянган төгрөгийн 2 мэдээлэл, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээших үнийн дүнтэй худалдан авсан ажил гүйлгээнээс 59,500.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3. "*Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*", 6 дугаар зүйлийн 6.4.5. "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр тус тус мэдээлнэ.*" заалтуудыг зөрчсөн. (НҮА, Зам засвар, арчлалт, Хан-уул Агро-100,286.9 мянга)

Шийдвэрлэсэн нь: Нэг байгууллагад 100,286.9 мянган төгрөгийн зөрчилд арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад өгч ажиллалаа.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ" -ийн баримтлалгүй 198,483.6 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна. /Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-120,080.0 мянга, НҮА-78,403.6 мянга/

Шийдвэрлэсэн нь: Нэг байгууллагад 120,080.0 мянган төгрөгийн зөрчилд арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, 107,403.6 мянган төгрөгийн зөрчилд цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад өгч ажиллалаа.

2. Тайлант онд зарласан тендерээр 306,887.5 мянган төгрөгийн ажил гүйцэтгэхээр гэрээ хийсэн боловч 412,771.2 мянган төгрөгийн ажил гүйцэтгэж, төлбөр төлөгдсөн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т заасны дагуу гэрээний дүнгээс 20 хувийг тооцон хасахад 44,506.3 мянган төгрөгийн илүү худалдан авалт хийсэн. /Зам засвар, арчлалт/

Шийдвэрлэсэн нь: Шалгагдагч байгууллагад зөрчилд арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

3. Хан-Уул дүүргийн ИТХ-ын 12 төлөөлөгч нарт 88,756.8 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргаж, чадавхжуулах зардалтай давхардуулан олгосон, төсвийн хөрөнгөөс улс төрийн намуудад 29,000.0 мянган төгрөгийн намын суудлын мөнгө өгсөн зэрэг нийт 117,756.8 мянган төгрөгийг үрэлгэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх шалгагдагч байгууллагуудад зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХ, Төсвийн тухай хуулийн зарим заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус дүүргийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 944,586.9 мянган төгрөгийн 27 алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 25 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Бусад байгууллагын дансанд бүртгэлтэй хөрөнгийг ЗДТГ-ын данс бүртгэлд давхардуулан бүртгэсэн, түүвэр тооллогоор биетээр байхгүй хөрөнгийг тодорхой болгож, зохих байгууллагуудад хандаж, шийдвэрлүүлээгүй зэрэг зөрчлүүдийг арилгаагүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 42,412.2 мянган төгрөгийн 10 төлбөрийн акт, 2,318,530.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлага, 1,095,604.2 мянган төгрөгийн 35 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	10	42,412.2	10	42,412.2	0	0	100.0
Албан шаардлага	15	2,318,530.5	15	2,318,530.5	0	0	100.0
Зөвлөмж	35	1,095,604.2	31	970,705.3	4	124,898.9	88.6
Нийт	60	3,456,546.9	56	3,331,648.0	4	124,898.9	96.2

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус дүүргийн дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйл ажиллагаа, орон нутгийн өмчит компаниудын эдийн засгийн зорилтод түвшинг үндэслэлтэй баталдаг эсэх, удирдлагын менежментийг оновчтой хэрэгжүүлж байгаа эсэх, орон нутгийн орлогыг хэрхэн оновчтой төлөвлөж байгаа эсэх, 2023-2024 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийн үлдэгдэлд биет тестийг завсрын аудитаар хэрэгжүүлэх болно.

ОНӨААН-үүдийн ажилтанд нэмэгдэл олгох зарим тушаалын заалт тодорхой бус, цалингийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоол, холбогдох эрх зүйн акттай нийцүүлсэн эсэхэд анхаарал хандуулах.

Дараагийн аудитаар “Эрүүл монгол” хөтөлбөртэй давхардуулан эрүүл мэндийн үзлэгийн зардал төсвийн хөрөнгөөс гаргасан эсэх асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 12 төсвийн байгууллага, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс нийт 20 байгууллага аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 8 байгууллага /ИТХ, ЗДТГ, ЖДҮДТ, ХААА, ДАА, УССТ, Туул тосгоны ЗАА, Соёлын ордон I, 4 сан, зардал /ОНХС, Хөрөнгө оруулалтын барьцаа, дүүргийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах /,аж ахуйн тооцоотой 8 байгууллага / "Хан эко тээвэр" ОНӨААТҮГ, "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ, "Эко ахмадын сувилал" ОНӨААТҮГ, "Хан-Уул Яармаг" ОНӨААТҮГ, "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ, Хан-Уул зам засвар арчлалт" ОНӨААТҮГ, "Хан-Уул агро" ОНӨААТҮГ, Нийтлэг үйлчилгээний алба/, санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2	-	14	-
2	ОНӨААН	-	4		
	Дүн	2	4	14	-

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" (дүүргийн ИТХ, ЗДТГ, "Хан-Уул зам засвар арчлалт" ОНӨААТҮГ, "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ, Нийтлэг үйлчилгээний алба) 5 санал дүгнэлт, "Хязгаарлалттай" ("Хан-Уул агро" ОНӨААТҮГ) 1 санал дүгнэлтийг тус тус өгсөн.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 2,385,955.3 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илрүүлснээс 70.1 хувь буюу 1,671,877.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулга хийлгэж, 1.1 хувь буюу 26,717.3 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17.8 хувь буюу 423,975.9 мянган төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 11.0 хувь буюу 263,384.7 мянган төгрөгийн 35 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар орон нутгийн ТШЗ-ийн хэмжээнд 152,532.2 мянга, ОНӨААТҮГ-уудын хэмжээнд 1,519,345.2 мянга, нийт 1,671,877.4 мянган төгрөгийн алдааг залруулсан. Тухайлбал:

- Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулаагүй үлдэгдэл 135,976.4 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг татаас санхүүжилтийн авлага үүсгэж тайлагнасан. /ЗДТГ-60,976.4 мянга, ИТХ-75,000. мянга/
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,923.7 мянган төгрөгийн хөрөнгийн орлогыг борлуулалтын орлогоор буруу тайлагнасан. /ЗДТГ/
- Бараа материалын тодруулга тайланд худалдан авсан 3,090.0 мянган төгрөгийн материалыг хандиваар илэрхийлсэн. /ЗДТГ/
- Сэргээн засаж, сайжруулсан засмал замын 11,542.1 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тоо хэмжээ, хуримтлагдсан үр дүнг тус тус нэмэгдүүлж тайлагнасан. /ЗДТГ/

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Зардлыг тооцооны данс, өглөгөөр дамжуулалгүй 1,140,930.7 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн. /Эко хотын тээвэр/
- Шатах тослох материалыг бараа материалын дансанд орлого, зарлагаар илэрхийлээгүй. /Эко хотын тээвэр/
- Цалингийн тооцоо бусад урьдчилгааг цалингийн өглөгийн дансаар дамжуулаагүй. /Эко хотын тээвэр/
- Үндсэн хөрөнгөнд 88,291.2 мянган төгрөгийн газрыг орлогоор бүртгэхдээ ангилал буруу бүртгэсэн. /Эко ахмадын сувилал/
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс 2,508.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгасныг ХХОАТ, санхүүгийн тайланд залруулсан. /Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ/
- ААНОАТ-ын зардлын 225.6 мянган төгрөгийг үйлчилгээний хураамжийн зардалд илэрхийлж, зардлын ангилал буруу бүртгэсэн. /Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ/
- ААНОАТ-ын зардлын 31,746.8 мянган төгрөгийг урсгал засварын зардалд илэрхийлж, зардлын ангилал буруу бүртгэсэн. /Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ/
- Нэг харилцагч байгууллага дээр баримтгүйгээр 107,119.4 мянган төгрөгөөр авлага, өглөгийг үүсгэж тайлагнасан. /Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ/
- Ажилчдад илүү олгосон урамшууллыг зардлаар тайлагнасан 5,950.0 мянган төгрөгийг авлагаар бүртгүүлж, санхүүгийн байдлын тайланд тусгаж, залруулсан. /Хан-Уул Агро ОНӨААТҮГ/
- Айл өрх, албан байгууллагын хог тээврийн хураамжийг өөрийн дансанд төвлөрүүлсэн 132,878.5 мянган төгрөгийг татварын албанд төлөх өглөгөөр бүртгэж, санхүүгийн байдлын тайланд тусгаж, залруулсан. /Хан-Уул Агро ОНӨААТҮГ/
- Үндсэн хөрөнгө актлахдаа 9,695.0 мянган төгрөгийн дансны бичилт буруу байсныг залруулсан. /Хан-Уул Агро ОНӨААТҮГ/

Дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.
(мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Үүнээс:											
		Залруулагдаагүй алдаа, зөрчил		төлбөрийн акт		албан шаардлага		зөвлөмж		хариуцлага тооцуулах санал		хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	21	231,949.3	1	18,728.2	2	121,601.4	18	91,619.7	-	-	-	-
2	ОНӨААН	30	482,128.6	3	7,989.1	10	302,374.5	17	171,765.0	-	-	-	-
	Дүн	51	714,077.9	4	26,717.3	11	423,975.9	31	263,384.7	-	-	-	-

5.1.1. Орон нутгийн байгууллага

Аудитаар залруулагдаагүй нийт 231,949.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 18,728.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 121,601.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 91,619.7 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 18 зөвлөмжийг холбогдох шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн. Тухайлбал:

² Хүчин тогтоолдор үйлчилж буй хууль тогтоомжид харилцах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.Төлбөрийн акт

Хөрөнгө оруулалт болон зардал данстай холбоотой асуудал:

- Хөрөнгө оруулалтын 2020, 2021 онуудын хийгдсэн ажлуудын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан, барьцааны хугацаа дууссан байтал гүйцэтгэгч байгууллагуудад нийт 18,728.2 мянган төгрөгийг буцаан олгоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” заалтыг зөрчсөн байна. (Хөрөнгө оруулалтын барьцаа)

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд төлбөрийн акт тогтоож шалгагдагч байгууллагад хүргүүлсэн.

2. Албан шаардлага

Зардлын данстай холбоотой асуудал

- Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Зөв төлөвшил” арга хэмжээнд 19,700,0 мянга, “Хариуцлагатай иргэн, өөрийн эрх үүргийг мэдье” арга хэмжээнд 19,800,0 мянга нийт 39,500.0 мянган төгрөг зарцуулахдаа удирдамж, төлөвлөгөө, хийсэн ажлын тайлан байхгүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ИТХ/
- Хөтөлбөр арга хэмжээний зардлын төсөвт хоол, цайны зардал 49,891.4 мянга, гарын авлага 32,210.0 мянган төгрөгөөр баталж, нийт 82,101.4 мянган төгрөгийн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ЗДТГ/

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдэд албан шаардлага тогтоож шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн.

5.1.2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд:

Аудитаар залруулагдаагүй нийт 482,128.6 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс 7,989.1 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 302,374.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, 171,765.0 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 17 зөвлөмжийг холбогдох шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн. Тухайлбал:

1.Төлбөрийн акт

Зардлын данстай холбоотой асуудал:

- Нотлох баримтгүй 1,392.3 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан, өдөр тутмын хэвлэл захиалгад 1,621.0 мянган төгрөг, захирал өөртөө тушаал шийдвэр гаргаж 2,000.0 мянган төгрөгийн урамшуулал авсан, бэлэг дурсгалын зүйл 1,750.0 мянган төгрөг зарцуулсан, нийт 6,763.3 мянган төгрөгийн үрэлгэн, баримтгүй зардлууд гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 “хэвлэлийн захиалгын төлбөр”; 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр шагнал, урамшуулал, дэмжлэг

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

олгох"; 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна /Хан-Уул Агро ОНӨААТҮГ/

2. Жилийн эцсийн тооллогын бүртгэлийг бараа материалын үлдэгдэлтэй тулгахад 1,225.8 мянган төгрөгийн шатахуун тооллогын бүртгэлд илэрхийлж тусгаагүй, тодруулахад бодиттой байхгүй гэсэн тайлбартай байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл Эд хөрөнгийн тооллого явуулах журам. 73.1.4 "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ" заалтыг зөрчсөн. /Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ/

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоож шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн.

2. Албан шаардлага

Авлага, үндсэн хөрөнгө болон бусад данснуудтай холбоотой асуудал:

1. Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй Шүүхийн шийдвэрийг үндэслэн 6,929.4 мянган төгрөгийн цалин олгосон нь буруу шийдвэр гаргасан этгээдээр төлүүлээгүй, авлага барагдуулаагүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заалтыг зөрчсөн. /Хан-эко тээвэр ОНӨААТҮГ/
2. Касс дах бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байхад харилцах данснаас захирал өөрийн болон нягтлангийн хувийн данс руу касс гэж татан авалт хийдэг, өөртөө чек бичиж бэлэн мөнгө авдаг, 146,900.0 мянган төгрөгийг харилцахаас татан авч, бэлнээр төлбөр хийх шаардлагагүй 122,924.3 мянган төгрөгийн шатахуун, сэлбэг, дугуй, гэрээт ажлын хөлс, бараа материал, цалин хөлс, урамшуулал олгох зэргээр бэлэн мөнгөөр тооцоо хийж байгаа нь бүртгэлээр тавих үе шатны хяналтгүй, зарцуулсан байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 "албаны эрх мэдлээ хэтрүүлэх"; Байгууллагын даргын 2022 оны А/21 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.1.2-т зааснаар "байгууллагын касс хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс бага хэмжээний үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээний төлбөрийг зайлшгүй бэлэн мөнгөөр гүйцэтгэнэ, ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлс, тэтгэмж, урамшуулал олгохдоо хүлээн авагчийн арилжааны банк дах цалингийн болон төлбөрийн картын үйлчилгээг ашиглана" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Хан-Уул Агро ОНӨААТҮГ/
3. Дүүргийн Засаг даргатай байгуулсан "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ"-г зөрчин байгууллагын дарга өөрийн төрсөн хүүг автомеханикчаар ажиллуулдаг, 11,000.0 мянган төгрөгийн цалин хөлсийг бэлнээр олгож байна. Энэ нь Дүүргийн Засаг даргатай байгуулсан "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ"-ний 4.2 заалт Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт нэг гэр бүлийн буюу төрөл садны хүмүүс хоорондын хяналт тавих болон захирах, захирагдах албан тушаалд хамт ажиллахыг хориглоно", гэж заасантай

- нийцээгүй санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Хан-Уул Агро ОНӨААТҮГ /
4. Түрээсийн автомашинаар жолооч зам тээврийн осол гаргаж иргэдэд учруулсан хохирлын 19,233.1 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрээр төлсөн, авлага үүсгэж бүртгээгүй, авлагын дансны насжилтын тайлан гаргаагүй, дансны авлага 10,350.7 мянган төгрөг, дансны өглөг 3,594.3 мянган төгрөгийн үлдэгдлүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай зөрчсөн. /Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ/
 5. Хүлэмжийн сайжруулалт, төмөр хашаа зэргийг хөрөнгөөр бүртгээгүй, зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах,” гэсэн заалттай нийцэхгүй бүртгэсэн байна. /Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ/
 6. Нийслэлийн өмчийн харилцааны газраар гэрээ батлуулаагүй 41,594.1 мянга, цахим и баримтгүй 32,189.7 мянга, баримт бүрдэл дутуу баримтаар 54,558.9 мянга, нийт 128,342.7 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэсэн байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” заалтыг хэрэгжүүлээгүй. /Хан-Уул Агро ОНӨААТҮГ-54,558.9 мянга. Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-41,594.1 мянга. Зам засвар, арчлалт-32,189.7 мянга/

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд албан шаардлага тогтоож шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн.

5.2. ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнг

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Тухайлбал:

1. Орлого, зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд чиг үүрэгт хамааралгүй улсын тэмдэгтийн хураамжийн орлого хүлээн авч тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2. "Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална" 33.2.1. "төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтуудтай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. (ИТХ)

Өгсөн зөвлөмж: Чиг үүрэгт хамааралгүй татварын орлого хүлээж авахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

1.2 Илрүүлэлт: Зарим байгууллагын ажилчид хотын тохижилт, бүтээн байгуулалт, туршлага судлах нэрээр 22,357.6 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "энгийн хялбар, чанга хатуу байх"; 4.1.3 "үр ашигтай байх"; 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; заалтуудыг хэрэгжүүлээгүй. (Туул тосгоны ажлын алба-7,600 мянга, УССТөв-4,850 мянга, Хан-эко тээвэр-9,907.6 мянга)

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх, үрэлгэн үр ашиггүй зардлыг хязгаарлах, төсвийг хэмнэлттэйгээр зарцуулж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

1.3 Илрүүлэлт: Ажиллагсдадаа 6,852.0 мянга төгрөгийн биеийн тамирын өмсгөл, угтах үйлчилгээний хувцас авсан, 8,374.9 мянган төгрөгийн цайны зардалд гаргасан зэрэг төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг хэрэгжүүлээгүй. (Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-1,452.0 мянга, Хан-эко тээвэр-1,009.3 мянга, Эко хотын тээвэр-589.3 мянга, Туул тосгоны ажлын алба-2,000.0 мянга, УССТөв-3,400 мянга, ЗДТГ-6,776.3 мянга)

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх, үрэлгэн үр ашиггүй зардлыг хязгаарлах, төсвийг хэмнэлттэйгээр зарцуулж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

1.4 Илрүүлэлт: Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж 13,200.0 мянган төгрөг, анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар 22,011.9 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4. нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.7. нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны 190 дугаар тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна. (Эко ахмадын сувилал-16,011.9 мянга, ТҮТ-6,000.0 мянга, ЗДТГ-13,200.0 мянга)

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, төсвийг бодиттой төсөвлөж, батлуулах, анхан шатны баримт бүрдэл хангаж ажиллах;

1.5 Илрүүлэлт: Батлагдсан орон тоонд байхгүй, албан тушаалд хавсран ажилласны 1,584 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон, ажилчдаа ажлын 6 өдөр ажиллуулдаг бөгөөд бүх нийтийн амралтын өдөр ажиллуулсан цалин тооцохдоо хуулийн дагуу илүү цагийн нэмэгдэл тооцохгүй ажлын өдөртэй адил тооцож олгосон зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 10/ "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлийн 109.1-д "илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно." заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй. (Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Дотоод аудитын алба-1.584.0 мянга)

Өгсөн зөвлөмж: Цаашид ажлын дотоод зохион байгуулалт сайжруулан, ажиллагсдыг хуульд заасны дагуу амралтыг нь эдлүүлж, төсвийг хэмнэлттэйгээр зарцуулж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

1.6 Илрүүлэлт: Шатахууны тооцоог түүвэрлэн тулгахад 7,300.0 мянган төгрөгийн тослох материалыг нэр төрөл, тоо хэмжээгээр бүртгээгүй, удирдах ажилтнууд авч хэрэглэсэн 9,521.3 мянган төгрөгийн шатахуундаа жолоочийн замын хуудас, зарцуулсан баримтгүй, өдөртөө 100-120км машин ашиглаж, шатахуун зарцуулж байгаа нь төрийн хөрөнгийг үрэлгэн хэмнэлтгүй зарцуулж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; заалтыг зөрчсөн. (Эко тээвэр ОНӨААТҮГ-9,521.3 мянга, Дотоод аудит-5,400 мянга, УССТөв-1,900 мянга)

Өгсөн зөвлөмж: Шатахууны нэр төрлийн тайлан гаргах, зарцуулалтыг автомашины 100 км-т зарцуулах шатахууны норм нормативаар тооцох, жолоочийн замын хуудас хөтөлж, эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах. Цаашид төсөв үндэслэлгүй төлөвлөгдөх, хяналтгүй зарцуулагдахыг анхаарч төсвийг хэмнэлттэйгээр зарцуулж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

1.7 Илрүүлэлт: Сэлбэг материалын зарцуулалтыг түүвэрлэн тулгахад автомашины гүйлт норм тооцож зарцуулдаг автомашины 17,541.8 мянган төгрөгийн дугуй, сэлбэгийг орлого авч, шууд зардлаар тайлагнасан байна. Энэ нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 5 дүгээр хавсралт "Автомашины сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм"-ыг заалтыг хэрэгжүүлээгүй. (Эко тээвэр ОНӨААТҮГ)

Өгсөн зөвлөмж: Автомашины сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм нормативаар тооцож, зардлаар хүлээн зөвшөөрөх, түүнд тавих хяналтыг сайжруулах. Цаашид төсөв үндэслэлгүй төлөвлөгдөх, хяналтгүй зарцуулагдахыг анхаарч төсвийг хэмнэлттэйгээр зарцуулж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

2. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Бусад байгууллагын дансанд бүртгэлтэй 38,709.4 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн байгууллагын данс бүртгэлд давхардуулан бүртгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө харууцна." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна. (ЗДТГ)

Өгсөн зөвлөмж: Давхар бүртгэлтэй хөрөнгийг тодорхой болгох, холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

2.2 Илрүүлэлт: Санхүүгийн тайланд үнэлж бүртгэсэн газруудыг цахим бүртгэлтэй тулган үзэхэд кадастрын зураг, нэгж талбайн дугаар нь баталгаажуулаагүй 4 объектын 19,295м2 хэмжээтэй, 174,525.0 мянган төгрөгийн газар, газрын гэрчилгээ гарсан боловч санхүүгийн тайланд газрыг үнэлж бүртгээгүй байгаа зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт,

хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” 13 дугаар зүйлийн 13.4. “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна. (ЗДТГ, Туул тосгоны ажлын алба, УССТөө)

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд бүртгэлтэй газруудыг газрын нэгдсэн мэдээллийн сантай дахин нягтлан тулган баталгаажуулан, баталгаажаагүй байгаа газруудыг зохих байгууллагуудад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

2.3 Илрүүлэлт: Бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 6,200.0 мянган төгрөгийн гар утасны апплейшн программыг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн боловч ашиглахгүй, НӨХГ-ын зөвшөөрөл, шийдвэргүйгээр 9,695.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйл “Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх” 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. (Хан-Уул Агро-9,695.0 мянга, ИТХ-6,200 мянга)

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг сайжруулах, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;

3. Тээврийн хэрэгсэл данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Сургуульд ашиглах 8 ширхэг 2,458,666.7 мянган төгрөгийн өндөр өртөгтэй хүүхдийн автобусыг ашиглагч тал биш тус байгууллагын санхүүгийн тайлан баланс бүртгэж тайлагнасан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1 “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

4. Авлага, өглөг данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Тайлан онд 38,380.0 мянган төгрөгөөр авлага нэмэгдсэн, 60,552.3 мянган төгрөгөөр өр төлбөр нэмэгдсэн, барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлээгүй, 1,104.5 мянган төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. (Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ)

4.2 Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн авлага, өглөгийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авах, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулах, санхүүгийн тайлан хүлээн авахдаа тооцоо нийлсэн акттай эсэхийг хянаж байх;

5. Дотоод хяналттай холбоотой асуудал

5.1.Илрүүлэлт: Дүүргийн харьяа байгууллагууд авлага, өглөг үүсгэсэн, төсвийг үрэлгэн зарцуулсан, бараа материалын тайланг үнэн зөв бэлтгээгүй, төрийн хэмнэлтийн хууль, заавар журмыг мөрдөөгүй зэрэг өмнөх онд гарсан зарим зөрчлүүдийг давтан гаргасан байна.

5.2.Өгсөн зөвлөмж: Дүүргийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нийслэл дэх төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдаа нэгтгэл /байгууллагаар/

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	75,000.0			1	75,000.0	1	75,000.0				
Засаг даргын Тамгын газар	4	77,532.2			4	77,532.2	4	77,532.2				
Орон нутгийн байгууллагын дүн	5	152,532.2	-	-	5	152,532.2	5	152,532.2	-	-	-	-
Эко хотын тээвэр	3	1,140,930.7			3	1,140,930.7	3	1,140,930.7				
Эко ахмадын сувилал	1	88,291.2			1	88,291.2	1	88,291.2				
Нийтлэг үйлчилгээний алба	4	141,599.8			4	141,599.8	4	141,599.8				
Хан-Уул Агро	3	148,523.5	2	138,828.5	1	9,695.0	3	148,523.5				
ОНӨААТҮГ-уудын дүн	12	1,561,845.2	2	138,828.5	10	1,423,016.7	12	1,561,845.2	-	-	-	-
Нийт дүн	16	1,671,877.4	2	138,828.5	14	1,533,048.9	16	1,671,877.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /байгууллагаар/

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	3	45,700.0			1	39,500.0	2	6,200.0						
Засаг даргын Тамгын газар	6	140,787.1			1	82,101.4	5	58,685.7						
Барьцаа хөрөнгө	1	18,728.2	1	18,728.2										
Дотоод аудит	2	6,984.0					2	6,984.0						
Усан спорт сургалтын төв	4	10,150.0					4	10,150.0						
Туулын тосгоны ажлын алба	5	9,600.0					5	9,600.0						
Орон нутгийн байгууллагын дүн	21	231,949.3	1	18,728.2	2	121,601.4	18	91,619.7	-	-	-	-	-	-

	7	204,941.5	2	6,763.3	4	188,483.2	1	9,695.0	
Хан-Уул Агро									
Зам засвар арчлалт	1	32,189.7							
Тохижилт үйлчилгээний төв	7	80,772.2							
Нийтлэг үйлчилгээний алба	2	1,104.5							
Эко ахмадын сувилал	5	39,238.5	1	1,225.8					
Хан эко тээвэр	3	17,846.3			1	6,929.4	2	10,916.9	
Эко хотын тээвэр	3	27,652.4					3	27,652.4	
Хан-Уул Яармаг	2	78,383.5					2	78,383.5	
ОНӨААТҮГ-уудын дүн	30	482,128.6	3	7,989.1	10	302,374.5	17	171,765.0	-
Бүгд дүн	51	714,077.9	4	26,717.3	12	423,975.9	35	263,384.7	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /байгууллагаар/ /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	-			1	-
Засаг даргын Тамгын газар	2	-	1		1	-
Дотоод аудит	1	10,348.6			1	10,348.6
ЖДҮД	1	15,800.0			1	15,800.0
Туул тосгоны ажлын алба	1	13,444.0			1	13,444.0
Орон нутгийн байгууллагын дүн	6	39,592.6	-	-	5	39,592.6
Тохижилт үйлчилгээний төв	1	-			1	-
Эко ахмадын сувилал	1	17,192.1			1	17,192.1
Хан эко тээвэр	1	7,110.0			1	7,110.0
ОНӨААТҮГ-уудын дүн	3	24,302.1	-	-	3	24,302.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	117,756.8			1	88,756.8
Орон нутгийн байгууллагын дүн	2	117,756.8	-	-	1	88,756.8
Тохижилт үйлчилгээний төв	1	120,080.0			1	120,080.0
Нийтлэг үйлчилгээний алба	2	78,403.6			2	78,403.6

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зам засвар, арчлалт	2	44,506.3			1	44,506.3	1	-
Хан-Уул Агро	1	100,286.9			1	100,286.9		
ОНӨААТҮГ-уудын дүн	6	343,276.8	-	-	3	264,873.2	3	78,403.6
Бүгд дүн	17	524,928.3	-	-	5	353,630.0	12	171,298.3